

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААН ДАХЬ ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГАА: ТУЛГАМДСАН АСУУДАЛ

CHILD ALLOWANCE IN FAMILY JUDICIAL RELATIONSHIPS: THE PROBLEM

**Н.Өнөржаргал**

*Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн магистр, ахлах дэслэгч*

Товч утга: Монгол улсад сүүлийн жилүүдэд гэр бүл болж байгаа хосуудын тодорхой хувь гэрлэлтээ бүртгүүлэн албан ёсоор гэр бүл болж байгаа бол ихэнх хосууд гэрлэлтээ бүртгүүлэхгүйгээр хамтран амьдарч байна. Гэрлэгчид гэр бүл цуцлах, хамтран амьдрагчид хамтын амьдарлаа дуусгавар болгосноор хүүхдийн тэтгэлэг төлөх асуудал урган гардаг. Шүүхээс хүүхдийн тэтгэлэг тогтоосон ч тэтгэлэг төлөгч нь тэтгэлэг төлөхгүй байх, төлөхөөс зайлсхийх зэрэг янз бүрийн шалтгаан, нөхцөлөөс үүдэн хүүдийн эрх ашиг зөрчигдөх явдал байсаар байна.

Түлхүүр үгс: Гэр бүл, хүүхэд, тэтгэлэг, амьжиргааны доод түвшин, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Abstract: In Mongolia, recently married couples have registered their private marriages to become official families, and couples are living together without registering their marriages. The issue of child support arises when married couples support their families and cohabitants become breadwinners. Children's rights are still violated due to various reasons and situations, such as child support, child support, and child support payments

Keywords: Family, children, alimony, minimum living standards, enforcement process.

Манай улсын тухайд 2022 оны эхний таван сард 6267 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 1743 хос гэрлэлтээ цуцлуулсан байна. Монгол улсад өнгөрсөн 2019, 2020 онд нийт 7500 гаруй гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэрлэлт цуцлахад хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нэн тэргүүнд тавигдах бөгөөд салсан гэр бүлийн 20 гаруй хувь нь өөрийн ухамсраараа хүүхдийн тэтгэмж өгдөг

бол бусад нь албадан төлүүлэхээр шийдвэр гүйцэтгэлийн байгууллагад ханддаг байна.

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлсээр хангах үүргийг эцэг, эх хүлээдэг. Хүүхдийн эрх ашиг үргэлж нэгт байх нь гэр бүлийн эрх зүйн харилцааны гол зарчмын нэг билээ. Хүүхдийн бие бялдар, оюун санаа, ёс суртахууны хөгжлийг хангах, сурч боловсроход эцэг, эх, адил үүрэг хүлээх нь хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчмын нэг. Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан ч гэсэн хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлага нь хэвээр үргэлжилнэ.

Гэрлэлт гэдэг нь 18 насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг⁵⁸ хэлдэг. Харин гэрлэлтийн гэрчилгээгээ аваагүй боловч гэр бүл болсон хүмүүсийг энгийнээр хамтран амьдрагч гэж нэрлэдэг.

Нэгэнт л эцэг, эх болсон бол насанд хүрээгүй, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг хүлээнэ⁵⁹. Хэрвээ гэрлэгчид гэр бүл цуцлах, хамтран амьдрагчид хамтын амьдралаа дуусгавар болгож буй тохиолдолд хүүхдийн эрх ашиг хамгийн их хөндөгдөж байдаг тул хүүхдийг хэн нь өөрийн асрамждаа авах, хэрхэн тэжээн тэтгэх талаар эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулдаг. Гэрээ байгуулаагүй бол тэтгэлгийг шүүх тогтооно.⁶⁰

Гэрлэлт түүнтэй харьцах цуцлалтын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд тухайн тоо баримтаар өдөрт 10 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 40 хос гэрлэлтээ бүртгүүлдэг⁶¹. Цуцлалтын тоо энэ байдлаар үргэлжлэх бол өдөрт гэр бүлээ батлуулж буй 40 хосын 10 нь салах эрсдэлтэйг тоо баримт сануулж байна.

Гэр бүл цуцлалтын тоо жилээс жилд дунджаар 269-өөр нэмэгдэж байна⁶². Гэр бүл салалтын шалтгааныг маш олон талаас тайлбарладаг. Гэр бүл салах шалтгаан нь юу ч байж болно. Гол нь түүнээс үүсэх хор хохирол нь гэрлэгчдээс гадна хүүхдүүдэд илрэх нь ойлгомжтой.

Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулж байгаа тохиолдолд хамгийн эхэнд хүүхдийн асрамжийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээсэн бол нөгөөхөөс нь тэтгэлэг гаргуулна. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай

⁵⁸ Гэр бүлийн тухай хууль., 1999он, 3-р зүйл

⁵⁹ Гэр бүлийн тухай хууль., 1999он, 38-р зүйл

⁶⁰ А. Батбаатар., Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал, УБ, 2021он, 72дахь тал

⁶¹ <https://ikon.mn/opinion/y5q>

⁶² <https://ikon.mn/opinion/y5q>

хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлсээр хангах⁶³ үүргийг эцэг, эх хүлээнэ гэж хуульд заасанчлан тэтгэлгийг өгөх үүрэгтэй.

Талуудын хэлэлцээгээр тэтгэлэг төлөх тохиолдолд тэтгэлэг тогтоох нөхцөл, тэтгэлгийн хэмжээг тогтооно. Тэтгэлэг тогтоох гэрээг гэр бүлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад нийцүүлэн бичгийн хэлбэрээр байгуулан нотариатаар гэрчлүүлнэ.⁶⁴

Тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг шүүх тогтоох⁶⁵ бөгөөд хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр тогтооно. Үүнд:

Арван нэг хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний 50 хувиар;

Жишээ нь: Улаанбаатарт өнөөдрийн байдлаар хүн амын амьжиргааны доод түвшин 313,400 төгрөг байна. Үүний 50 хувь нь 156,700 төгрөг байна.

11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшний хэмжээгээр тогтооно. Амьжиргааны доод түвшний хэмжээг үндэсний статистикийн газраас тогтоодог.

Манай улсын хувьд амьжиргааны доод түвшин 2023 оны байдлаар:

- Баруун бүс-274,400
- Хангайн бүс-282,500
- Төвийн бүс-272,300
- Зүүн бүс-271,800
- Улаанбаатар-313,400⁶⁶

Зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй.

Жишээ нь: Өнөөдрийн байдлаар Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550,000 төгрөг бол түүний 50 хувь буюу 275,000 хэтэрч болохгүй.

Хүүхдийн тэтгэлгийг мөнгөн хэлбэр эсвэл эд хөрөнгөөр олгож болох бөгөөд сар, улирал, хагас жил, бүтэн жилээр, эсхүл нэг удаа бөөнд нь олгож болно.

Хэрэв тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болдог. Тухайлбал: 18 нас хүртэлх хугацаанд нийт хэдэн төгрөг төлөхөөс, төлөгдөөгүй үлдсэн нь хэд вэ? гэдгийг бодоод дээр нь алданги тооцоод нэхэмжлэх боломжтой. Харин тэтгэлэг нөхөн төлүүлэхэд

⁶³ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 1996, 12 дугаар зүйл

⁶⁴ . Даваажав, С. Оюунчимэг., Монгол улсын гэр бүлийн эрх зүй, УБ, 2014 он, 122 дахь тал

⁶⁵ Ж. Амарсанаа., хүүхдийн эрхийн нэр томъёоны тайлбар толь, УБ, 2001 он, 66 дахь тал

⁶⁶ <http://eagle.mn/r/110641>

тэтгэлэг төлөгч хөдөлмөр эрхлээгүй буюу цалин хөлс, бусад орлогын хэмжээг тогтоох боломжгүй бол тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтална. Тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн хугацааны тэтгэлгийн хэсгийг буюу бүхэлд нь нөхөн төлүүлэхээс шүүх чөлөөлж болдог.⁶⁷

Монгол улсад 2022 оны байдлаар хүүхдийн тэтгэлэг гаргуулах асуудлаар шүүх 383⁶⁸ маргааныг шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2022 оны мэдээгээр хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэвэл зохих 13526 гүйцэтгэх хуудасны 47.789.271,0 төгрөгийн баримт бичиг байснаас 1272 гүйцэтгэх хуудасны 20.078.703.8 төгрөгийн баримт бичгийг гүйцэтгэсэн байна.

Төлөгдөөгүй 14.707 хүүхдэд олгогдох 27.710.567,9 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг байгаагаас тогтмол төлөлттэй 7109 хүүхдэд холбогдох 145.322,8 төгрөгийн 5923 гүйцэтгэх баримт бичиг, төлөгдөлгүй хуримтлагдсан 7598 хүүхдэд олгогдох 27.855.890,0 төгрөгийн 6396 гүйцэтгэх баримт бичиг байна.

Үүнийг хүүхдийн насны байдлаар авч үзвэл 0-11 насны 12142 хүүхдэд холбогдох 20.587.026,9 төгрөгийн, 11 ба түүнээс дээш насны 2565 хүүхдэд холбогдох 7.123.540,3 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг байна.

Төлбөр төлөгдөхгүй байгаа шалтгааныг авч үзвэл:

- Төлбөрийн чадваргүй 349 гүйцэтгэх хуудасны 2.772.445,8 төгрөгийн,
- Оршин суух хаяг тодорхойгүй 380 гүйцэтгэх хуудасны 2.768.801,4 төгрөгийн,
- Хорих ял эдэлж байгаа 56 гүйцэтгэх хуудасны 320.188,0 төгрөгийн,
- Эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа 245 гүйцэтгэх хуудасны 2.316.198,8 төгрөгийн,
- Хэсэгчлэн төлөлттэй 6221 гүйцэтгэх хуудасны 19.053.351,6 төгрөгийн,
- Бусад шалтгаантай 5003 гүйцэтгэх хуудасны 479.581,6 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг байна.

Дээрх мэдээнээс харвал хүүхдийн тэтгэлгийг цаг тухайд нь төлдөггүй, төлөхөөс зайлсхийдэг тохиолдол маш их байгаа нь харагдаж байна.

Тэгвэл тэтгэлэг төлөгч нь шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй тохиолдолд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага авдаг байна.

Мөн Зөрчлийн тухай хуульд “тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй /100,000/ тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос

⁶⁷ А. Батбаатар., Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал, УБ, 2021он, 78 дахь тал

⁶⁸ <https://shuukh.mn/cases/1/1>

гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.”⁶⁹ хэмээн заасан байдаг.

Дүгнэлт

Гэрлэгчид гэр бүл цуцлах, хамтран амьдрагчид хамтын амьдралаа дуусгавар болгож буй тохиолдолд хүүхдийн эрх ашиг хамгийн их хөндөгдөж байдаг тул хүүхдийг хэн нь өөрийн асрамждаа авах, хэрхэн тэжээн тэтгэх талаар эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулдаг. Гэрээ байгуулаагүй бол тэтгэлгийг шүүх тогтоодог.

Гэрлэлт түүнтэй харьцах цуцлалтын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Монгол Улсын хэмжээнд тухайн тоо баримтаар өдөрт 10 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 40 хос гэрлэлтээ бүртгүүлдэг байна. Жилд 7200 гэр бүл салахад үүнээс зөвхөн 383 нэхэмжлэл шүүхэд гаргаж байгаа нь хүүхдийн тэтгэлгийн талаар иргэд эрх зүйн мэдлэг дутмаг байгааг нэг талаараа илтгэж байна.

Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулж байгаа тохиолдолд эхний ээлжид хүүхдийн асрамжийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээн нөгөөхөөс нь тэтгэлэг гаргуулна. Тэтгэлэг төлөгч нь хуульд заасны дагуу тэтгэлгийг төлөх үүрэг хүлээдэг ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээнээс харахад хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхгүй байх тохиолдол их байна.

Тиймээс иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа, төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд хүүлээлгэх хуулийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

Санал

1. Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үнэт зүйлийн талаар ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах.
2. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийг төлөхгүй байгаа тэтгэлэг төлөгчийг албадан хөдөлмөрлүүлж цалин хөлснөөс тэтгэлгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах талаар зөрчлийн хуульд тусгах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Ж. Амарсанаа., Хүүхдийн эрхийн нэр томъёоны тайлбар толь, УБ, 2001он
2. А. Батбаатар., Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал, УБ, 2021он
3. Х. Отгонтуяа., Монгол улсын гэр бүлийн тухай хууль, түүний хэрэгжилт., УБ, 2009он
4. Гэр бүлийн тухай хууль., 1999он
5. Зөрчлийн тухай хууль., 2017он

⁶⁹ Зөрчлийн тухай хуулийн 6.20.6

6. Б. Даваажав, С. Оюунчимэг., Монгол улсын гэр бүлийн эрх зүй, УБ, 2014 он
7. <https://shuukh.mn/cases/>
8. <http://mongolcom.mn/read/12399>
9. <https://isee.mn/n/31129>
10. <https://ikon.mn/n/uom>
11. <http://www.taniltsuulga.ubstat.mn/une7.aspx>

---o0o---